

Гэрээний тусгай нөхцөл

Бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдсон захиалагч болон нийлүүлэгч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.

- Захиалагч нь Цэнхэр дэлхий 10-р цэцэрлэг
- Ахлах тогооч, нярав, эмч, байгууллагын дотоод хяналтын баг тухайн бараа бүтээгдэхүүнийг шалгаж авна. Шаардлагад нийцээгүй бараа бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй бөгөөд буцаах эрхтэй, буцаахад гарсан зардлыг нийлүүлэгч өөрөө хариуцна.
- Гэрээний дагуу бараа материалыг графикийн дагуу нийлүүлж байх. Үүнд:
- Махыг 14 хоногт 1 удаа
- Хүнсний ногоог 14 хоногт 2 удаа
- Талх, нарийн боовыг 7 хоногт 2 удаа
- Бусад хүнсний материалыг 14 хоногт 1 удаа
- Сүү, сүүн бүтээгдэхүүнийг 7 хоногт 3 удаа
- Нийлүүлж буй махыг битүү савлагаанд хийж нийлүүлж байх
- Нийлүүлж буй ногоог шороо хогноос нь салгаж, чийггүй хатаасан ногоо нийлүүлж байх
- Техникийн тодорхойлолтонд заасан шаардлагын дагуу нийлүүлж байх
- Талх нарийн боов нь шинэ, зөөлөн амт чанар сайтай байх
- Цэцэрлэгийн хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон илчлэг шим тэжээлийг хангахуйц хоолны материалыг нийлүүлж байх
- Нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол нь бүрэн бүтэн тухайн бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал алдагдаагүй байх. Тээвэрлэлтийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон хадгалалтын халуун хүйтэн, давс хур тунадас зэргийг тэсвэрлэхээр байна.
- Техникийн тодорхойлолтын дагуу бараа нийлүүлнэ. Захиалагч байгууллагад бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэгч өөрөө хариуцан хүргэж өгөх.
- Захиалагч барааны төлбөрийг дараах журмын дагуу хийнэ: Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний үнэ төлбөрийг нэхэмжлэлийн дагуу сар бүрийн 28-ны дотор төлнө.

- Хугацаа хоцорч нийлүүлсэн бараанд алданги оногдуулж гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алданги оногдуулах хувь: /0,5%/
- Бэлтгэн нийлүүлэх бараа бүтээгдэхүүн нь МХГ-ын шинжилгээгээр хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх үзүүлэлтийг хангасан дүгнэлттэй байна.
- Нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг сар улирлын онцлог болон нийтийг хамарсан өвчлөлийн үед хүүхдийн тоо буурах үед нийлүүлэх бараа бүтээгдэхүүний тоо багасаж өөрчлөгдөн гэрээний дүн буурч болно.
- Хүлээн авахдаа хайрцаг савны байдал, хаяглалыг шалгана. Хайрцаг саван дээр үйлдвэрлэсэн огноо, хадгалах горим, цэвэр бохир жин зэргийг заасан шошготой байна. Нийлүүлэгчийн хүлээн авч байгаа барааг тоо, чанарын шалгалт хийж хүлээн авсны дараа ямар нэг зөрчил дутагдал илэрвэл нийлүүлэгчээс 2 талын төлөөлөгчийг байлцуулан бараа нийлүүлэх гэрээнд заасны дагуу нөхөж бараа ирүүлэхийг шаардана.
- Бараа нийлүүлэх бүртээ шинжилжилгээний бичгийг цаг тухай бүрт авчирч байх
- Зарлагын падаан, нэхэмжлэлийн эх хувиар нь баримтаа ирүүлж байх

Үнэлгээний хороо: Дарга Ц.Өлзийжаргал

Н/б дарга Б.Энхтөгс

Гишүүн Б.Насанжаргал